



Ag Re

ХӨДӨӨ АЖ АХУЙН
ДАВХАР ДААТГАЛ ХК

ЖИЛИЙН
ТАЙЛАН 2016



Итгэл дүүрэн
Амжилт өөд

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсад давхар даатгалын тогтолцоог анхлан нэвтрүүлж, хөгжүүлэхэд чухал хувь нэмрээ оруулж буй санхүү, даатгалын салбарын төлөөлөл, хамтран ажиллаж буй иргэд, аж ахуйн нэгж Та бүхэнд Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуурт болгох, болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнээс хамгаалах, зорилгоор санхүүгийн салбарын хөгжлийг шинэ шатанд авчрах “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг үүсгэн байгуулсан билээ.

Хөдөө аж ахуйн салбар нь ДНБ-ийн 20 гаруй хувийг дангаар үйлдвэрлэж, үндэсний үйлдвэрүүдийг түүхий эдээр хангаж, нийт ажиллах хүчний 35 орчим хувь нь ажилладаг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинг тодорхойлдог салбар юм. Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарыг байгаль цаг уурын болзошгүй аюулаас сэргийлэх шинэ тогтолцоо бий болгох хүрээнд Малын Индексжүүлсэн Даатгал төслийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд малчин түмэнд үр шимээ өгсөн бодит ажил хэрэг болж, индексжүүлсэн даатгалд хамрагдах малчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байгаа нь сайшаалтай. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын индексжүүлсэн даатгалаас гадна 2016 онд газар тариалангийн салбарт туршилтын журмаар даатгалын бүтээгдэхүүн гаргасан бөгөөд цаашид илүү боловсронгуй тариалангийн индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Экспортын орлогын 90 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаар эзэлж буй энэ үед бусад салбарын экспортыг дэмжих, эдийн засгийг солонгоруулах, экспортын баримжаатай үндэсний брэнд бүтээгдэхүүн бий болгохоор Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих төсөл”-ийн хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь экспортын санхүүжилтийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, экспортын даатгалын бүтээгдэхүүн боловсруулахаар ажиллаж байна.

Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэн, даатгалын зах зээлийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, институцийн чадавхийг бэхжүүлэх, дотоодын даатгагчдын эрх ашгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах санхүүгийн тогтолцоог бий болгохоор Засгийн газрын зүгээс зорин ажиллаж байгаа бөгөөд ингэснээр давхар даатгалын салбарыг шинэ түвшинд авчирч, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НЯМАА

УДИРДЛАГЫН ИЛГЭЭЛТ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн эрхэм харилцагч, хамтран зүтгэгч та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Бид Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн нэгэн тулгуур багана болсон хөдөө аж ахуйн салбарыг байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлсээс хамгаалах, санхүү даатгалын зах зээлд давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлэх үндсэн зорилгоо үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын бүс нутгийн газарзүйн онцлог, байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдал нь нүүдлийн мал аж ахуйг хамгаалах, малчин түмний амьжиргааны баталгааг төрөөс зайлшгүй хамгаалах шаардлага бий болгодог. Малын индексжүүлсэн даатгалын тогтолцоонд оролцогч даатгалын компаниуд тэдгээрийн орон нутаг дахь төлөөлөгчид, мөн олон улсын давхар даатгалын компаниуд нь хамтдаа Монгол орны үндэсний баялаг болсон мал сүргийг хамгаалах ажилд хамтран зүтгэж байгаа билээ.

Хөдөө аж ахуйн салбарыг нийтэд нь даатгалын хамгаалалтад оруулах, хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахад даатгалын гэрээгээр дамжуулан оролцох үүргээ бид бүхэн газар тариалангийн салбарт туршилтын журмаар даатгалын системийг нэвтрүүлснээр гүйцэтгэж байна. Олон улсын нэр хүнд бүхий давхар даатгалын компаниудын ирүүлсэн саналууд, бид бүхний хийсэн актуар тооцооллын үр дүнд олон төрлийн эрсдэлээс хамгаалсан газар тариалангийн стандарт бүтээгдэхүүнийг зах зээл дээр санал болгож, цаашдаа газар тариалангийн салбарыг даатгалын хамгаалалтад бүрэн хамруулахаар ажиллаж байна.

Өнгөрсөн 2016 онд бид малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг орон даяар хоёр дахь жилдээ зохион байгуулж даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо 45 хувь, хураамжийн орлого 26 хувиар тус тус өсч чамгүй үр дүнтэй жилийг ардаа үдлээ. Цаашид бид үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж хөдөө аж ахуйн салбараас гадаадад экспортод гарч буй бүтээгдэхүүнийг дэмжих, экспортлогч аж ахуйн нэгжүүдэд тулгардаг үндсэн бэрхшээл болох худалдан авагч талаас үүсдэг аливаа эрсдэлийг бууруулах зорилгоор Дэлхийн банктай хамтран экспортын даатгалын охин компанийг байгуулан, дэлхийн жишигт хүрсэн экспортын даатгалын бүтээгдэхүүнийг зах зээл дээр нийлүүлэх болно.

Манай компанийн хамт олон та бүхний хүсэл, шаардлагад нийцсэн, зах зээл дээр өрсөлдөх чадвартай даатгалын үйлчилгээг нэвтрүүлж, харилцагч, үйлчлүүлэгчдээ сонсон тэдний хэрэгцээг цаг алдалгүй давуулан биелүүлж, та бүгдтэй үргэлж хамтран ажиллах болно.

ТАНЫ АЖИЛ ҮЙЛС, АМЬДРАЛД ХАМГИЙН САЙН САЙХНЫГ ХҮСЬЕ!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЭНХТАЙВАН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧ
О.НАРАНХҮҮ

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-д үндэслэн Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тушаалаар байгуулагдсан.

АЛСЫН ХАРАА

Монгол Улсын даатгалын тогтолцоог олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангана.

ҮНДСЭН ЗОРИЛГО

Даатгагч, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай давхар даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон, худалдан борлуулах замаар оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөхөд оршино.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын хөдөө, аж ахуйн салбарыг бүхэлд нь хамарсан эрсдэлийг хамгийн бага түвшинд бууруулах замаар иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих Хөдөө аж ахуй, санхүүгийн салбарын хөгжлийг шинэ шатанд авчрахад оршино.


ЗОРИАТ

- Малчдын амьжиргааг зудын эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;
- Монгол Улсын давхар даатгалын чиг хандлагыг тодорхойлогч компани болох;
- Дотоодын давхар даатгалын санхүүгийн чадавхийг бэхжүүлэх;
- Даатгалын зах зээлд тогтвортой оршин тогтнож, байгууллагын санхүүгийн тогтвортой өсөлтийг хангаж ажиллах;
- Түүнчлэн Олон улсын давхар даатгагчдын гүүр болж, олон улс дахь бизнесийн харилцаагаа өргөжүүлэх;
- Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх;
- Даатгалын чадварлаг боловсон хүчин бэлтгэх

Компанийн хувьцаа эзэмшигч нь Сангийн яам бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор батлагдсан “Сайн дурын даатгалын хэлбэр”-т заасан “Малын индексжүүлсэн даатгал” (МИД), “Газар тариалангийн даатгал” болон бусад хэлбэрийн даатгалд давхар даатгалын үйлчилгээ үзүүлэх юм.

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН БҮТЭЦ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 5 газар нэгжтэй. Үүнд: Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Экспортын даатгалын газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Санхүү удирдлагын газар орно.



ТУЗ-ийн дарга: **Б.НЯМАА**
Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

ТУЗ-ийн гишүүд: **Н.МАНДУУЛ**
Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга

М.ЖАЛАВДОРЖ
“МИГ даатгал” ХХК-ийн дэд захирал

Л.ЧОЙ-ИШ
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

А.ДЭМБЭРЭЛ
Үндэсний статистикийн хорооны Статистикийн эрдэм шинжилгээ, арга зүйн газрын дарга

Д.НАСАНЖАРГАЛ
“Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо”-ны Удирдах зөвлөлийн гишүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүд: **Б.ШАРАВСАМБУУ** Хараат бус гишүүн **Ц.ТҮМЭНХИШИГ** Хараат бус гишүүн **К.АЛИЯ** Хараат бус гишүүн




САНХҮҮГИЙН ГОМЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


2016 онд манай компанийн нийт хөрөнгө өмнөх жилээс 35 хувиар буюу 9.1 тэрбум төгрөгөөр өсч нийт 35.5 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарын нийт хөрөнгийн 17 хувийг эзэлж байна. Энэхүү хөрөнгийн өсөлт 35 хувьтай байгаа нь нийт нөөц сан, өөрийн хөрөнгө тус тус 39.5 ба 14.5 хувиар өссөнтэй холбоотой байна. 2016 оноос малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнийг банкаар дамжуулан борлуулалт хийж эхэлснээр нийт 18,738 айл өрх даатгалд хамрагдсанаас 40 хувь нь буюу 7497 айл өрх банкаар дамжуулан даатгалд хамрагдсан байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар 1357.1 сая төгрөгийн хураамж төвлөрүүлснээс 413.6 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байгаа нь тус даатгалын бүтээгдэхүүний хувьд хохирол нөхөлтийн харьцаа үзүүлэлт 41 хувьтай байна. Санхүүгийн зах зээлийн хүү өссөн үр дүнд богино хугацаат хөрөнгө оруулалтын орлогоо 25 хувиар нэмэгдүүллээ.


НИЙТ ДААТГАЛЫН ХУРААМЖ /ТЭРБУМ ТӨГРӨГ/




ЦЭВЭР АШИГ /ТЭРБУМ ТӨГРӨГ/



НИЙТ НӨӨЦ САН 2015-2016/ТЭРБУМ ТӨГРӨГ/



НИЙТ ХӨРӨНГӨ 2015-2016 /ТЭРБУМ ТӨГРӨГ/





ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2016 оны 4 дүгээр сарын 01-нээс 7 дугаар сарын 30-ны хугацаанд МИД-ын борлуулалтыг Хаан банк болон Төрийн банкттай зуучлалын гэрээ байгуулан, мөн 8 даатгалын компанитай /Бодь, Монгол, Монре, МИГ, Практикал, Тэнгэр, Ард, Хаан/ хамтарч хийсэн бөгөөд нийт 18715 малчдыг хамруулж 1 тэрбум 774 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн нь өмнөх оныхоос 38 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

- 2015 онд малаа даатгуулсан даатгуулагч нарт олгох нөхөн төлбөрийг тооцоолоход Архангай, Булган, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Сүхбаатар, Төв, Увс, Ховд аймгийн нийт 61 сумын 3133 малчинд 413,6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олголоо.

- МИД-ын чиглэлээр Олон Улсын давхар даатгалын “SCOR”, “Swiss Re”, “Qatar Re” компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Мөн “SCOR”, “Swiss Re” нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

- “Нэрлэсэн эрсдэлт тариалангийн даатгал”-ыг зах зээлд гаргахтай холбогдуулж Сэлэнгэ, Төв аймгийн 10 сумдад туршилтын журмаар хэрэгжүүлж, нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгалын бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ. Сэлэнгэ аймгийн Хушаат сумын даатгуулагчийн улаан буудай тариалсан 250 га орчим талбайг даатгалд хамруулж, улаан буудайн даатгалын анхны гэрээг байгууллаа. Түүнчлэн, “SCOR” олон улсын давхар даатгалын компанитай давхар даатгалын гэрээ байгуулж, улаан буудайн даатгалын нийт эрсдэлийн 80%-ийг

“SCOR” хариуцаж, 20%-ийг дотооддоо хариуцан ажилалаа. Энэхүү гэрээ нь газар тариалангийн бүтээгдэхүүн тэр дундаа улаан буудайг давхар даатгах анхны гэрээ болж байгаа бөгөөд хөдөө аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах чухал ач холбогдолтой гэрээ юм.

- Бизнес хөгжил, төслийн газар, Андеррайтингийн газрын төлөөлөл Lloyd’s Asia дээр компанийн үйл ажиллагааг сурталчлан, талууд бүх төрлийн давхар даатгалаар хамтарч ажиллаж Монгол Улсын даатгалын салбарын чадавхийг дээшлүүлэх боломж байгааг талаар санал цохон тэмдэглэлээ. Хөдөө аж ахуйн давхар даатгалын компанийн чадавхыг сайжруулах ялангуяа андеррайтар болон хохирол үнэлгээний чиглэлээр Сингапур болон Лондон дахь салбарт сургах, хамтарсан судалгааны ажил хийх талаар санал солилцлоо. Мөн Lloyd’s Asia Монгол Улсад гамшгийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх, бүтээгдэхүүн боловсруулахад туслалцаа үзүүлэх боломжтой хамтарч ажиллах сонирхолтой гэдгээ илэрхийлсэн юм.

- Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг зардал багатай, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх зорилгоор цаг уурын мэдээлэлд суурилсан газар тариалангийн индексжүүлсэн даатгалыг судлан ажиллаж байна.

- ОХУ-ын давхар даатгалын “Russian Re” компанитай 2016 оны 6 дугаар сард даатгалын зах зээл дэх үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэх зорилгоор

санамж бичигт гарын үсэг зурав.

- Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциац хооронд байгуулсан “Экспортыг дэмжих төсөл”-ийн хүрээнд уул уурхайн бүс салбар дахь Монгол Улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн экспортын чадавхийг бэхжүүлж, гадаад зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, экспортын худалдааны даатгалыг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхээр судлан ажиллаж байна.




МИД-ЫН 2016 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн хоёр дахь жилийн борлуулалт буюу МИД-ын арван нэг дэх борлуулалтын улирал 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 21 аймгийн нийт 330 суманд эхэлснээс хойш 2016 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд оролцогч даатгагчид болох Ард, Бодь, Монгол, Монре, МИГ, Практикал, Тэнгэр, Хаан зэрэг даатгалын компаниуд болон зуучлалаар Төрийн банк, Хаан банк оролцон нийт **18,738 малчинтай** Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын гэрээг байгуулж, **1 тэрбум 774 сая** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн **12.24%**-ийг эзэлж байгаа нь өнгөрсөн онд даатгуулсан малчин өрхийн тооноос 8,421 өрхөөр, даатгалын хураамжийн орлого 460 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН БОЛОН ЗУУЧЛАЛЫН БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН




“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь ХААН банк болон Төрийн банкаар дамжуулан МИД-ийн хураамжийн зээл болон МИД-д малаа даатгуулсан малчдад хөнгөлөлттэй зээлийг олгодог. 2016 онд ХААН банкаар дамжуулан 1088 малчин 4,491 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, ХААН банк болон Төрийн банкаар дамжуулан 6 малчин 1,9 сая төгрөгийн хураамжийн зээлийг тус тус авсан байна.

МИД-ЫН БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН


Малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүнд хамрагдсан малчин өрхийн тоо, хураамжийн орлогыг 2006 оноос хойш харахад давхардсан тоогоор нийт 112 мянга орчим малчин өрх 20.3 сая малыг даатгалд хамруулж 9.356 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлсэн бол үүнээс давхардсан тоогоор 20 мянган малчин 3.644 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

МИД-Д ХАМРАГДСАН МАЛЧИН ӨРХИЙН ТОО, МАЛЧИН ӨРХӨД ЭЗЛЭХ ХУВЬ



¹ 2006-2009 онд даатгалд хамрагдсан малчин өрхийн тоо, борлуулалтын орлогыг авахдаа ҮДБ болон ГХБ-д хамрагдсан малчин өрхийн тоо, ҮДБ ГХБ-ний нийт орлогоор авсан болно.

МИД-ЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУРААМЖИЙН ОРЛОГО /САЯ ТӨГРӨГӨӨР/





МИД-ЫН 2015-2016 ОНЫ НӨХӨН ТӨЛБӨР

Үндэсний статистикийн хорооноос 2016 оны хагас жилийн мал тооллогын албан ёсны дүн мэдээг хүлээн авч 2015 онд малаа даатгуулсан даатгуулагч нарт олгох нөхөн төлбөрийг тооцооллоо. Тооцооллоор Архангай, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Төв, Увс, Ховд аймгуудын нийт 61 сумын 3133 малчин өрхөд 413,638,948.38 төгрөгийн нөхөн төлбөрийг олгох дүн мэдээ гарсан. Дорноговь аймгийн Айраг суманд үхрийн хорогдол 25.27%, Дэлгэрэх суманд мөн үхрийн хорогдол 29.01%, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд үхрийн хорогдол 32.27%, адууны хорогдол 25.92% гарч тус аймгуудын хоёрдугаар босго үзүүлэлт болох 25%-аас давж дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас нөхөн төлбөр олгохоор болсон.



2015 онд МИД-ын борлуулалт хийсэн 6 даатгалын компанид нөхөн төлбөр болох 413.6 сая төгрөгийг Хамтын эрсдэлийн сан болон Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сангаас гарган шилжүүлж 8 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15 хүртэлх хугацаанд бүрэн олгож дууссан.

ХҮСНЭГТ №1. 2015-2016 ОНЫ МИД-ЫН НӨХӨН ТӨЛБӨР /АЙМАГ, МАЛЫН ТӨРЛӨӨР/

№	Аймаг	Нөхөн төлбөр авах малчин өрхийн тоо	Нөхөн төлбөр					Нийт дүн
			Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	
1	Архангай	162	646,405.36	39,550.00	4,321,198.55	217,250.03	0.00	5,224,403.93
2	Баянхонгор	946	31,811,291.93	29,552,166.04	25,153,025.25	0.00	173,731.64	86,690,214.86
3	Булган	51	775,572.41	1,622,610.93	2,351,058.09	0.00	0.00	4,749,241.42
4	Говьсүмбэр	5	0.00	672,660.00	253,361.00	0.00	0.00	926,021.00
5	Дорноговь	227	402,619.60	18,258,345.34	22,491,922.16	7,757,677.42	0.00	48,910,564.52
6	Дорнод	38	0.00	663,325.00	0.00	0.00	0.00	663,325.00
7	Дундговь	29	0.00	3,581,644.20	0.00	0.00	0.00	3,581,644.20
8	Завхан	97	2,212,855.70	5,011,819.82	1,073,214.33	0.00	0.00	8,297,889.85
9	Сүхбаатар	198	4,476,913.47	19,977,550.39	30,678,573.99	2,077,399.00	24,850.00	57,235,286.85
10	Төв	97	509,765.14	1,187,274.15	3,128,564.25	453,941.79	0.00	5,279,545.33
11	Увс	1,227	59,962,255.83	97,994,661.78	27,127,162.33	2,504,981.06	433,791.02	188,022,852.03
12	Ховд	56	721,423.33	3,336,536.06	0.00	0.00	0.00	4,057,959.39
Нийт		3,133	101,519,102.76	181,898,143.71	116,578,079.95	13,011,249.29	632,372.66	413,638,948.38

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Монгол Улсын эдийн засгийн тулгуур хөдөө аж ахуйн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 14 хувийг, үүнээс 20 хувийг нь газар тариалангийн салбар бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны үр дүнд газар тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн тоо 2016 оны байдлаар 1490-д хүрч, жилдээ 400 гаруй тэрбум төгрөгийн газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Монгол Улсад гарах байгалийн гамшиг, гэнэтийн аюул эрсдэлийн тоо хэмжээ нэмэгдэж, судалгаагаар бүрэн болон хэсэгчилсэн ургац алдсан үр тарианы талбайн хэмжээ 2015 онд 108.5 мянган га байсан бөгөөд энэ нь тариалсан талбайн 30 хувь нийт ургацын 50 гаруй хувийг алдаж, хөдөө аж ахуйн салбарт 33 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан бол 2016 онд 49,5 мянган га талбайн ургацыг алдаж 26,0 тэрбум төгрөгийн хохирол учруулжээ.

2016 ОНЫ УРГАЦ ХУРААЛТЫН ДҮН

№	Таримлын төрөл	Тарьсан талбай (мян.га)	Ургац алдсан талбай (мян.га)	Хураасан талбай (мян.га)	Нэгж ургац (цн)	Нийт ургац	Хангамж, %	Ургацад учирсан шууд хохирол /тэрбум төгрөг/
1	Үр тариа	377.3	32.3	345.0	13.8	475.8	-	20,4
	Үүнээс бүүдай	355.3	25.4	329.9	14.0	460.7	+100.0	16,3
2	Төмс	14.5	0.145	14.4	105.1	153.7	+100.0	4,1
3	Хүнсний ногоо	8.3	0.139	8.2	112.1	93.5	56.0	
4	Тэжээл	28.1	1.1	29.2	17.3	50.6	40.0	-
5	Тосны ургамал	63.8	17.0	46.8	3.1	19.6	46.3	4,1
	Дүн	492.0	49.5	442.5	-	-	-	26,0

Эх үүсвэр: ХХАХУЯам

Иймд «Хөдөө аж ахуйн давхар даатгал» ХК-аас санаачлан олон улсын зөвлөхтэй хамтран тариалангийн да-атгалын бүтээгдэхүүний загварыг боловсруулж, эхний ээлжинд нийт газар тариалангийн талбайн 73 хувийг, үүнээс үр тарианы 90 гаруй хувийг дангаар эзэлж байгаа улаанбуудайг түршилтын журмаар давхар даатгах зорилгоор Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Цагааннуур, Түшиг, Хүдэр, Хушаат сүмдүүд болон Төв аймгийн Цээл сумын тариалан эрхлэгчдэд санал болгосон.

Улаанбуудайн даатгалын бүтээгдэхүүн нь газар тариалан эрхэлж буй (улаанбуудай тариалж буй) этгээдийг байгаль, цаг уурын болон бусад урьдчилан сэргийлэх боломжгүй нэр бүхий эрсдэлээс шалтгаалан ургац ал-дах, улмаар эдийн засгийн хохирол хүлээх эрсдэлээс хамгаалах зорилготой юм.

Түршилтын хугацаанд дээрх сүмдын тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал”, “Мандал даатгал” ХХК-иудтай хамтран улаанбуудайн даатгалын бүтээгдэхүүнийг хэрэгжүүлсэн. Түр-шилтын үр дүнд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын аж ахуйн нэгжийн тариан талбайг “Бодь даатгал” ХХК даат-гаж, энэхүү гэрээг дотооддоо “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК давхар даатгаж, гадагшаагаа SCOR олон улсын давхар даатгалын компанид даатгуулсан болно.

Цаашид тариалангийн даатгалыг улам боловсронгуй болгож, даатгуулагчийн эрэлт хэрэгцээнд тулгуурла-сан тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхийг зорьж байгаа бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.

ЭКСПОРТЫН ШИНЭ ТӨРЛИЙН САНХҮҮГИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭХ

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь Монгол Улсын Засгийн газар, “Дэлхийн Банк”-ны Олон улсын хөгжлийн ассоциацийн хамтын ажиллагаатайгаар уул уурхайн бус салбарт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээг гадаадын зах зээлд экспортлоход дэмжлэг үзүүлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, цаашилбал дан ганц уул уурхайн гаралтай түүхий эдийн экспорт давамгайлсан, гадаад худалдааг илүү эрүүл, шинэ тогтолцоогоор солих, эдийн засгийг солонгоруулж, аюулгүй байдлыг нь бэхжүүлэх зорилго бүхий “Экспортыг дэм-жих төсөл”-ийг хэрэгжүүлэх нэгжээр томилогдлоо.

Энэхүү төслийг 2013 оны 9 дүгээр сард экспортыг дэмжих хөтөлбөр дээр үндэслэн Засгийн газраас баталсан бө-гөөд Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлоготой УИХ-ын 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 104 дүгээр тогтоол; Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлоготой УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 62 дугаар тогтоол; Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр 2014-2016-тэй Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн тогтоолоор тус тус үялдаж байгаа болно.

Төслийн үр дүнд бид худалдааны даатгал хэмээх санхүүгийн нэгэн үйлчилгээний төрлийг дотоодынхоо ба-раа бүтээгдэхүүн экспортлогч аж ахуй нэгжүүддээ танилцуулж, худалдан авагчаас бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ төлбөрийг авч чадахгүй байх болзошгүй тодорхой эрсдэлүүдээс хамгаалагдах боломж, нөхцөлийг үйлдвэрлэл эрхлэгчиддээ олгох юм.

Түүнчлэн Монгол Улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, гадаад зах зээлд экспорт хийхэд шаардлагатай мэдлэг, үр чадвар олж авах, түршлага судлах боломж олгохоос гадна экспортлогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлж, даатгалын тодорхой зорилтот зах зээлүүдэд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх юм. Манай компани нь төслийн үндсэн зорилтот бүлэг буюу гадны зах зээл дээр бараа бүтээгдэхүүн гаргах хүсэлтэй, эсвэл гаргадаг уул уурхайн бус салбарт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн талаар холбогдох судалгаа, шинжилгээнүүдийг хийн, төлөөлөл холбоодын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, эхний ээлжинд шаардлагтай байгаа зохих арга хэмжээнүүдийг аваад байна.

2016 оны байдлаар Монгол Улсын нийт экспортын хэмжээ 4,9 тэрбум ам.доллар байсан бөгөөд үүний 70,8 хувь нь уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн, 6 хувь нь ноолууран бүтээгдэхүүний орлогоос бүрдэж байна. Харин уул уур-хайн гаралтай бүтээгдэхүүний экспортын 95 хувийг БНХАУ-руу экспортолж байна.

Экспорт нь уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнээс хэтэрхий хамааралтай байгаа нөхцөлд экспортын төрөлжил-тийг бий болгосноор бүтээгдэхүүний үр ашгийг нэмэгдүүлж, ажиллах хүчнийг хөгжүүлж, зах зээлд шинэ бүтээгдэхүү-нийг гаргадаг. Хэдийгээр уул уурхайн салбарын ажилтнууд хөдөлмөрийн бүтээмж өндөртэй ч нийт ажиллах хүч-ний ердөө 4 хувийг бүрдүүлж байна. Гэтэл хөдөө аж ахуйн салбар нийт ажиллах хүчний 40 орчим хувийг бүрдүүлж байгаа ч хөдөлмөрийн бүтээмж, эдийн засгийн үр ашиг харьцангуй бага байна. Иймээс хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд эдийн засгийн төрөлжилт хийж чадвал хөдөлмөр эрхлэлт болон улсын эдийн засгийн бүтээмжинд өндөр хувь нэмэртэй юм.

Өндөр үр бүтээмж, цалин, татварын төлөлт, гадаад орлого нь улсад шинэ хөрөнгө оруулалт, хэрэглээг бий бол-гох бөгөөд эдгээр хүчин зүйл нь амьжиргааны бага орлоготой хүн амд эерэгээр нөлөөлөхөөс гадна жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөгжүүлснээр улс орны ядуурлыг бууруулж, эдийн засгийг хөгжүүлэн, хөгжлийн түвшинг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах юм.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ТАНАА

ДҮГНЭЛТ

Бид “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайланд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь матери-аллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотол-гоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Холбогдох нөөцийн сангуудын бүртгэл, тайлагналтай холбоотой зохицуулалт бүрэн хийгдээгүй байгаатай хол-боотойгоор үүсч болзошгүй эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд шаардлагатай журмуудыг боловсруулж мөрдөх. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажиллах.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын даруу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбо-отой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуу-лагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ж.ЦЭЦЭГМАА

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-ны өдөр
(мян.төг)

ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
	2015.12.31	2016.12.31
хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,509,842.9	231,318.5
Даатгалын авлага	156,007.2	128,952.9
Бусад санхүүгийн хөрөнгө	376,121.7	721,782.0
Санхүүгийн бус хөрөнгө		
Татвар НДШ-ийн авлага	0.8	
Бараа материал	3,133.3	8,311.5
Урьдчилж гарсан зардал/тооцоо	3,000.0	
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	6,134.1	8,311.5
Хөрөнгө оруулалт		
Хадгаламж, хадгаламжийн сертификат		17,889,431.4
Засгийн газрын үнэт цаас	16,997,271.2	14,999,930.9
Хөрөнгө оруулалтын дүн	16,997,271.2	32,889,362.3
Даатгалын хөрөнгө		
Давхар даатгалын хойшлогдсон хураамж		428,088.9
Даатгалын хөрөнгийн дүн		428,088.9
Үндсэн хөрөнгө	350,869.5	639,221.1
Биет бус хөрөнгө	6,930.0	467,660.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,403,176.6	35,514,697.3
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын өглөг		
Санхүүгийн бус өр төлбөр		
Цалингийн өглөг	0.7	
Татвар, НДШ-ийн өглөг	39,340.9	21,606.4
Бусад БХӨТ		2,730.6
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	39,341.6	24,337.0
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц		1,008,701.8
Нөөц сан		
Алдагдлаас хамгаалах сан	7,000,000.0	9,500,000.0
Хамтын эрсдэлийн сан	591,056.6	846,425.9
Эрсдэлээс хамгаалах сан	535,000.0	3,065,790.7
Нөөц сангийн дүн	8,126,056.6	13,412,216.6
Өр төлбөрийн нийт дүн	8,165,398.2	14,445,255.4
ЭЗДИЙН ӨМЧ		
Эздийн өмч	15,000,000.0	15,000,000.0
Эздийн өмчийн бусад хэсэг	86,476.6	684,332.9
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,151,301.8	5,385,109.0
Эздийн өмчийн дүн	18,237,778.4	21,069,441.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	26,403,176.6	35,514,697.3

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31-ны өдөр
(мян.төг)

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
Нийт хураамжийн орлого	446,599.2	994,613.4
Давхар даатгалын хураамж	(185,623.64)	(352,810.9)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	260,975.8	641,802.5
Нийт төлсөн нэхэмжлэл	-	4,613.8
Даатгалын хураамжийн орлогын дүн	-	637,188.8
Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр	-	(367,344.2)
Давхар даатгалын комиссын орлого		2,200.5
Хөрөнгө оруулалтын орлого	3,326,094.3	4,439,231.0
Бусад орлого		510.0
Даатгалын хураамжийн бус орлогын дүн	3,326,094.3	4,441,941.5
Даатгалын орлогын дүн	2,843,358.8	4,711,786.1
Үйл ажиллагааны зардал	(992,246.5)	(1,534,775.4)
Үндсэн үйл ажиллагааны ашиг	1,851,112.3	3,177,010.7
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(53.0)	(392.0)
Татварын төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,851,059.3	3,176,618.7
Орлогын татварын зардал	114,576.8	195,620.5
Татварын дараах ашиг (алдагдал)	1,736,482.5	2,980,998.2



ГАДААД ТҮНШҮҮД:

SCOR

Swiss Re

LLOYD'S

berneunion

Liberty
Specialty Markets

SOMPO CANOPIUS

QatarRe

RUSSIANRE

ДОТООД ТҮНШҮҮД:

ARD ДААТГАЛ
КОМПАНИ

ХААН БАНК
ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД

ТӨРИЙН
БАНК
ЭРСЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

МАНДАН
даатгал

МОНГОЛ ДААТГАЛ
Синс 1934
УНДЭСНИЙ ДААТГАЛЫН КОМПАНИ

МОНРЕ
ДААТГАЛ

ПРАКТИКАЛ
даатгал

ХААН ДААТГАЛ
Эрдэс баян даатгал / Эрдэс баян даатгал

МИГ
МОНГОЛ
ДААТГАЛ

ТЭНГЭР
ДААТГАЛ

НОМИН
ДААТГАЛ



Хаяг:

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ ХК
UBH Center, 14 давхар, 1406 тоот
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө-23,
Улаанбаатар хот
Монгол улс



Утас: (+976) 75770002



Э-шуудан: info@agreinsurance.mn



Web: www.agreinsurance.mn

Facebook: [/www.agreinsurance.mn](https://www.facebook.com/agreinsurance.mn)

Twitter: [/AgReinsurance](https://twitter.com/AgReinsurance)